

Монгол Улс ба БНХАУ-ын хооронд 1962 онд хилийн гэрээ байгуулсны 60 жилийн ой энэ жил тохиож байна. Академич С.Нарангэрэлийн аав Б.Содовсүрэн гуай эл гэрээг байгуулахад оролцсон БНМАУ-ын Засгийн газрын таван төлөөлөгчтэй комиссын гишүүний нэг нь байсан ажээ. Нэрт хуульч, эрдэмтэн Б.Содовсүрэн гуай энх тунх байхдаа туулж өнгөрүүлсэн амьдралынхаа замналыг “Нууцалсан өв” хэмээсэн дурсамжид бичээд 1990-ээд оны эхээр хүүхдүүддээ өгч хадгалуулжээ.

Энэхүү дурсамжийн “Тусгаар тогтнол бэхжив” бүлгийг академич С.Нарангэрэлийн зөвшөөрөлтэйгээр Монгол Улс ба БНХАУ-ын хооронд 1962 онд хилийн гэрээ байгуулсны 60 жилийн ойг тохиолдуулан нийтийн хүртээл болгож байна. Зүүлт, тайлбарыг нь академич С.Нарангэрэл үйлдсэн болно.

“Тусгаар тогтносон улсын гол шинж бол тухайлсан нутаг дэвсгэртэй, хилийн шугамтай, түүнээ найдвартай батлан хамгаалах явдал мөн. Тус улсын хилийн урт 8158,0 км бөгөөд хойд талаараа ОХУ, зүүн, баруун, баруун урд талаараа БНХАУ-тай хамгийн урт хиллэнэ. Гоминданы болон Японы талаас 1935-1939 онд Халхын голоор, 1947-1948 онд Байтаг Богдоор БНМАУ руу зэвсэглэн довтолж, эх орныхоо тусгаар тогтнол ба нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлын төлөө эх оронч эрэлхэг хөвүүд амь насаа золиож, цусаа урсгасан түүхтэй ...

“Гадаад монголын тусгаар тогтнолыг одоогийн хилээр хүлээн зөвшөөрч байна” хэмээн 1945 оны 8 дугаар сарын 14-нд Хятадын Засгийн газар мэдэгдсэн боловч Монголыг Хятадын салшгүй хэсэг гэж үздэг хуучин хэвшмэл сэтгэлгээндээ баригдсаар байлаа. Улсын хилийг хоёр тал албан ёсоор хүлээн зөвшөөрөлцөөгүй, түүхэн ёсоор тогтсон хил байсан учир БНМАУ-ын Засгийн газар анх санаачилж, 1957 оны 11 дүгээр сарын 21-нд БНХАУ-ын Засгийн газарт дипломат шугамаар хоёр улсын хилийн шугамыг “одоогийн хилээр” тодотгон тогтоох хэлэлцээ явуулах санал тавьсан ноотыг илгээсэн юм. БНХАУ-ын Засгийн газраас 1958 оны 3 дугаар сарын 28-нд БНМАУ-ын Засгийн газарт илгээсэн хариу ноотдоо Хятад ба Монголын хилийн хэлэлцээ явуулахыг зөвшөөрч байгаага нотлохын зэрэгцээ БНМАУ-ын зүгээс “одоогийн хил” гэсэн нь хил тодотгон тогтоох зарчмын үндэс болохыг мэдэгдэв.

Манай улсын Засгийн газар ноотыг судалж үзээд хилийн хэлэлцээг яаравчлан эхлүүлэх зорилгоор ардын хувьсгал ялснаас хойш эзэмшин хамгаалж ирсэн “одоогийн хил”-ийн шугамаа газрын зураг дээр зурж тодорхойлон БНХАУ-ын Засгийн газарт 1958 оны 7 дугаар сарын 18-ны өдөр ноотоор хүргүүлжээ.

Хятадууд хилийн шугамын явалтын тодорхой саналыг манайхаас хүлээж авсныхаа дараа 1958 оны намраас эхлэн хилийн шугамын дагуу олон тооны хүн хүч бүхий ажлын хэсгийг гаргаж, газар хэмжих, газрын зураг үйлдэх, хилийн овоо, тэмдгүүд дээр шинээр тоо, дугаар тавих, нэмж мод босгох, гадас хатгах зэргээр бэлтгэл ажлыг өрнүүлжээ.

БНМАУ-ын хилийн шугамын дагуу хилийн зөрчил улам бүр ихэсэж, БНХАУ-ын зүгээс мал бүхий иргэдээ улсын хилд их ойртуулах, улмаар зориуд нүүлгэн хил давуулж нутагшуулах, орон байр, хашаа хороо барих, худаг ус гаргах, газар хагалах зэргээр өөрийн эзэмшлийн ул мөрийг үлдээх оролдлогыг тасралтгүй хийх болсон юм. Ийм нэн эгзэгтэй нөхцөлд буюу 1962 оны 6 дугаар сарын 11-нд БНХАУ-ын Засгийн газар Монгол-Хятадын хилийн 1600 км урт буюу 30 хэсэг нутаг дэвсгэрт 16 мянга км² газрын маргаантай, зарим хэсэгт хилийн шугамыг 40 км-ээр дотогшлуулах¹ саналтай байгаагаа илэрхийлсэн хариу өгсөн.

1962 оны 10 дугаар сарын 15-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын өмнөөс хилийн хэлэлцээрт оролцох бүрэн эрхт төлөөлөгчдийг БНМАУ-ын Гадаад яамны нэгдүгээр орлогч сайд С.Сосорбарамар² даргалуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргын нууц захирамжаар томилов. Ийнхүү БНМАУ ба БНХАУ-ын хилийн шугамыг тодотгон тогтоох эхний хэлэлцээр манай улсын нийслэл Улаанбаатар хотод нууц байдалд эхэлсэн юм. Тус улсын Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд элчин сайд Д.Цэрэндорж³, генерал Д.Батаа⁴, Гадаад яамны ажилтан Б.Цэдэн-Иш⁵ бид тав⁶ томилогдон шинжээч, нарийн бичгийн дарга,

¹ Өөрөөр хэлбэл, манай улсын хилийн шугамаас 40 км-ийн гүн орсон нутаг дэвсгэрийг авна гэсэн үг.

² Монголын төр, нийгмийн зүтгэлтэн. МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, Соёлын яамны сайд, БНМАУ-аас БНХАУ, БНПАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байжээ.

³ Монгол Улсын дипломатч, Гадаад явдлын яаманд ахлах референт, БНМАУ-аас БНХАУ-д суугаа Элчин сайдын яаманд зөвлөх, БНМАУ-аас БНАВУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан.

⁴ Монгол Улсын төрийн зүтгэлтэн, генерал. Дотоод явдлын яамны сайд, дэд сайдаар ажилласан. БНМАУ-аас Вьетнам, Румын, Куба, Болгар улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан.

⁵ Хилийн хэлэлцээрийн үед Гадаад явдлын яамны хилийн экспертийн дарга – консулын хэлтсийн даргаар ажиллаж байсан. Монгол Улсын хил хамгаалалтын гарамгай зүтгэлтэн. 1962 онд БНХАУ-тай, 1976 онд ЗХУ-тай хил тогтоох улсын комиссын бүрэлдэхүүнд оролцож байжээ.

⁶ Миний аав энэ үед БНМАУ-ын Дээд шүүхийн орлогч дарга бөгөөд Иргэний хэрэг эрхэлсэн шүүх коллегийн даргаар ажиллаж байжээ. Үүнээс үүдэн шүүгчээр ажиллаж байгаа хүнийг БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулж ажиллуулсаны учир нь сонирхол ихээхэн татдаг. Миний үзэж байгаагаар ингэх болсон гурван шалтгаан байгаа болно: Нэгдүгээрт, Татан буугдсан Шүүх явдлын яамны зарим чиг үүргийг Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазын хороо ба Улсын дээд шүүх гүйцэтгэж байсан. Энэ учраас Улсын дээд шүүхийн удирдлагаас оролцуулах шаардлага үүдэгджээ. Тийм учраас аавыг “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн хуулийн хорооны гишүүн” хэмээсэн халхавчийн албан тушаалтай болгосон байдаг. Үүнтэй холбоотойгоор БНХАУ-ын Засгийн газрын төлөөлөгчидтэй хилийн хэлэлцээ хийх БНМАУ-ын Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнийг томилсон тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргын нууц захирамж гарсан байж болох талтай; Хоёрдугаарт, Хилийн хэлэлцээрт олон улсын нийтийн эрх зүйн мэдлэгтэй хүн нэн чухлаар шаардагдсан бөгөөд миний аав тухайн үедээ ЗХУ-ын Москва хотын Ломносовын нэрэмжит Улсын Их Сургуулийг хуульчийн мэргэжлээр дүүргэсэн цөөхөн мэргэжилтний

техникийн ажилтан 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийн аппарат Гадаад яамны байранд ажилласан юм. Комисст хурандаа Д.Намжилдорж⁷, Ц.Шагдар⁸, М.Батхуяг⁹, Э.Халтар¹⁰, Б.Ламжав¹¹, Х.Шарав¹² нарын зэрэг эх орныхоо торгон хилийн шугам дээр идэр насаа өнгөрүүлсэн ахмад дайчид шинжээчээр оролцсон явдал өмнөд хилийн дагуух уул ус, даваа гүвээ, бут сөөг, хад чулуу, зам харгуй, сайрыг таван хуруу шигээ мэддэг байсан төдийгүй асуудал шийдвэрлэхэд Засгийн газрын төлөөлөгчид бидний ажилд маш их тус болов. Хилийн хэлэлцээ амжилттай болоход эрдэмтэн Д.Бадамжав¹³, орчуулагч С.Эрэнцэнсоном¹⁴, Д.Алмаас¹⁵ нарын гүйцэтгэсэн үүргийг орхигдуулах аргагүй.

Хэлэлцээрийн үндсэн зорилго бол хилийн шугамыг газрын зураг дээр тохиролцож, хилийн гэрээний эх бичвэрийг бэлтгэх ажил байсан юм.

БНХАУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийг БНХАУ-ын Гадаад яамны орлогч сайд Зе-Пен Пеэй тэргүүлж, тус яамны хэлтсийн дарга Зо-Зен-Ей, Хятад-монголын хилийн хариуцлагатай ажилтан, генерал Жей-Тей нар хэлэлцээрт голлох үүрэгтэй оролцсон бөгөөд БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орноос хэн нэгнийг төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцуулаагүй.

БНМАУ ба БНХАУ-ын хилийн түүхт хэлэлцээрт оролцохдоо БНХАУ-ын гадаад бодлого, дотоодын байдал өөрчлөгдөн цаашид хурцдахыг төсөөлж байснаас хэдэн сар сэтгэлийн гүн хямралд хөдөлмөрлөсөн БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийг нөхөр Юмжаагийн Цэдэнбал биечлэн удирдаж, хэлэлцээрийн

нэгэн байжээ; Гуравдугаарт, Хилийн хэлэлцээрт оролцох төлөөлөгчид нь туйлын эх оронч хүмүүн байх ёстой байсан бөгөөд миний аав энэ шалгуурыг давсан нэгэн байжээ.

⁷ Монгол Улсын хил хамгаалалтын албаны туршлагатай удирдах албан тушаалтан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертээр ажилласан.

⁸ Монгол Улсын хил хамгаалалтын албаны туршлагатай удирдах ажилтан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертээр ажилласан.

⁹ Монгол Улсын хил хамгаалалтын албаны туршлагатай удирдах албан тушаалтан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертээр ажилласан.

¹⁰ Монгол Улсын хил хамгаалалтын албаны туршлагатай удирдах албан тушаалтан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертийн группын ахлагчаар ажилласан.

¹¹ Монгол Улсын газар зүйн зургийн нэр гарсан мэргэжилтэн. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертээр ажилласан.

¹² Монгол Улсын хилийн цэргийн удирдах албан тушаалтан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертээр ажилласан.

¹³ Газар зүйн ухааны эрдэмтэн Д.Бадамжав нь ШУА-ийн газар зүй, цэвдэг судлалын хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн дарга, тасгийн эрхлэгч, ахлах ажилтнаар ажиллаж байсан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн экспертээр ажилласан.

¹⁴ Гадаад явдлын яамны хариуцлагатай ажилтан. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн орчуулагчаар ажилласан.

¹⁵ Монголын нэртэй орчуулагчдын нэг. 1962 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд хил тогтоох хамтарсан комиссын Монголын талын ажлын хэсгийн орчуулагчаар ажилласан.

явцтай тогтмол танилцаж, бидний сэтгэлийн шаналгаа зовиурыг Засгийн газрын тэргүүний хувьд байнга хуваалцаж байв. Миний бие БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн төсөл боловсруулах үеэр техникийн ажилд оролцон даргын дэргэд хэд хоног ажиллахдаа түүний зан төрх, ажилсаг чанарыг мэдэрсэн юм. Харин хилийн хэлэлцээрийн хэдэн сард улс төрийн алсын хараатай, эх оронч, хүнлэг сэтгэлтэй, өндөр боловсрол, өргөн мэдлэгтэй төрийн жинхэнэ зүтгэлтэн болохыг нь гадарлаж, хүнийх нь хувьд өрөвддөг болов.

Нөхөр Ю.Цэдэнбал манай орны тусгаар тогтнолтой амин холбоотой хилийн хэлэлцээрт онцгой ач холбогдол өгч, бидний хүчийг сэлбэсэн төдийгүй засаг төрийн тэргүүн эх орон, ард түмнийхээ аюулгүй байдлын төлөө хэчнээн их шаналж, БНХАУ-ын дотоод хямрал хурцдаж манай эх орны тусгаар тогтнолд аюул тулгарч байна гэдгийг мэдэрч байсан юм¹⁶.

Хоёр талын хүчин чармайлтаар Той тогос, Булган гол, Байтаг Богд, Хавтаг уул, Говь ингэн ус, Цагаан Богдын чиглэл, Их хонгорж, Заацын хар овоо, Сулин хээр, Шаргал шовгор, Хангилаг булаг, Ламтын дөш, Их айл, Нөмрөгийн овоо зэрэг 30 хэсгийн 16 мянган шоо дөрвөлжин нутаг, тэрчлэн манай талын саналаар Соёлч уул, Буян голын эх, Даваажавын манхан, Хятадын төлөөлөгчдийн саналаар Шарилжийн голын хойд хэсэг, Хайртын даваа, Халзангийн даваа, Хэрлэн голын хоёр тохой зэрэг нийт 37 хэсэгт 17 мянган шоо дөрвөлжин газрын маргаан үүсэж, саналын зөрүүг арилгах нэг ёсны “цусгүй дайн” эхэлсэн юм. Хэлэлцээрийн явцад 30 хэсэг газрын 10-ыг нь БНМАУ-д, 6-г нь БНХАУ-д харъяалуулах, 14 хэсэг газрыг хувааж эзэмшихээр тохирч, Соёлч уулын хэсгийг БНМАУ-ын эзэмшилд шилжүүлэх болов. Тооны хэлээр бол хэлэлцээрийн объект 17321 км² нутаг дэвсгэрийн 12314 км²-ыг¹⁷ БНМАУ-д, 5007 км²-ыг БНХАУ-д хамааруулахаар санал тохиролцож, хилийн шугамын бусад хэсгийг хөндөөгүй. Ийнхүү манай комисс хилийн заставын хуучин буйр, түүхийн ач холбогдол бүхий уул ус, хил хамгаалагчдын дурсгалт өндөрлөгийг хөндүүлэхгүй¹⁸ гэсэн зарчимт байр сууриа хамгаалж чадсан юм.

¹⁶ Миний аав энэ өгүүллийг 1990-ээд оны эх үеэр бичсэн юм. Энэ цаг үед Ю.Цэдэнбал даргыг элдвээр дайрч давшлах, эрхэмбээрийн нэр төрийг гутаах явуулга эрчимжиж байхад үнэнийг үнэнээр нь хойч үедээ үлдээхийг аав маань ийнхүү хичээж байжээ.

¹⁷ Энэ нь Гренад (344 км²) улсаас 35 дахин, Люксембург (2600 км²) улсаас 4 дахин, Мальдив (298 км²) улсаас 41 дахин, Мальт (316 км²) улсаас 38 дахин, Сингапур (619 км²) улсаас 19 дахин, Тонга (699 км²) улсаас 17 дахин том нутаг дэвсгэр юм. Гамби улс 11300 км², Катар улс 11300 км², Кипр улс 9200 км², Ливан улс 10400 км², Пуэрто-Рики улс 8900 км², Ямаик улс 11400 км² нутаг дэвсгэртэй ажээ.

¹⁸ Хилийн хэлэлцээ эхлэх өмнө БНМАУ-ын Засгийн газрын комиссоос нөгөө талдаа хэлэлцээ явуулах журам, шийдвэрлэх асуудлын талаар тодорхой санал оруулжээ. Тухайлбал, “... хилийн хэлэлцээ эхлэхийн өмнө урьд нь гарч байсан хилийн маргааныг авч хэлэлцэхгүй, хилийн шугамыг тодорхойлохдоо БНМАУ-ын одоогийн хилийн шугамаас үндэслэхийн учир дайны үед улсын хилээ

Эх орон, ард түмнээ гэсэн чин сэтгэл, үүрэг ба хариуцлага, тэсвэр тэвчээр, мэдлэг мэргэжил, дипломат урлагийн аль алиныг шалгасан амаргүй ажлыг улс орны гадаад байдал хурцадсан эгзэгтэй нөхцөлд нойр, хоолоо хасч, сэтгэлийн гүн хямралд ажиллаж, эх орныхоо урд хилийг албан ёсоор тогтоосон нь юуны өмнө БНХАУ-д болсон соёлын хувьсгалын самуун жилүүдэд цайз болж, хятадын зүгээс эх оронд маань учруулах байсан ноцтой аюулыг зайлуулж чадсан юм.

Монгол Улс ба БНХАУ – хөрш орны түүхэнд үлдсэн эмзэг асуудлыг шийдвэрлэн Бээжин хотноо 1962 оны 12 дугаар сарын 26-нд Ю.Цэдэнбал¹⁹, Жоу Эньлай²⁰ нар “Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Бүгд Найрамдах Хятад Улсын хилийн гэрээ”²¹-г үзэглэснээр миний эх орны гэрийн буйр хөдөлшгүй засагдаж, улс орны маань тусгаар тогтнол баталгаажин бэхжсэн юм.

Эх орныхоо тусгаар тогтнол ба нутаг дэвсгэрийн төлөө хичээл зүтгэл, оюун мэдлэгээ харамгүй дайчилсан хэсэг нөхдийн ариун үйлс түүхнээ мөнхөрч, ач холбогдлоо хэзээ ч алдахгүй. Түүхт энэхүү гэрээг хоёр улсын төрийн эрх барих дээд байгууллага батламжилж, НҮБ-д бүртгэгдсэнээр Монгол Улсын өмнөд хил олон улсын эрх зүйн баталгаатай болж, өмнөд хөрштэй хилийн шугамын талаар элдэв маргаан үүсэх ямар ч нөхцөлгүй болгосон билээ”.

---oOo---

хамгаалж байсан Монголын хилийн застав ба хилийн манааны байрууд халдашгүй хэвээр үлдэх ёстой” гэсэн санал байв.

¹⁹ БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга.

²⁰ БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд. БНХАУ-ын төрийн нэрт зүтгэлтэн.

²¹ “БНМАУ ба БНХАУ-ын хилийн гэрээний 1 дүгээр зүйлд “Монгол, Хятадын хилийн шугамын баруун үзүүрийн эхлэх цэг болох Монгол Алтайн нуруу (Алтайн нуруу)-ны Таван Богд уул (Хүйтэн уул)-ын 4050 тоот өндөрлөгөөс эхлэн хилийн шугамын явалт нь Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймгуудын нутаг дэвсгэрээр үргэлжлэн явсаар зүүн үзүүрийн эцсийн цэг болох 645,0 тоот өндөрлөг хүрнэ. Энэ зүйлд дурдсан хоёр улсын хилийн нийт шугамыг Монгол, Хятад хил дээр үйлдсэн бөгөөд энэхүү гэрээнд хавсрагдсан 1:1 000 000 маштабын газрын зурагт тэмдэглэж тодорхойлов” гэж заажээ.